



СЭЛЭНГЭ АЙМАГ  
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/85.

Алтанбулаг

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын  
зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авах  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5, "в", 29.1.6 "а", "ж", "л", 39 дүгээр зүйлийн 39.1, 39.2, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.9, 10.4.14, 10.7.32, дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.3, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 70 дугаар зүйлийн 70.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйл 11.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 91 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан 2021 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 06:00 цагаас 4 дүгээр сарын 25-ны өдрийн 00:00 цаг хүртэл нийслэл, бусад аймаг болон сумаас сум хооронд зорчих хөдөлгөөнийг хязгаарлаж, сум доторх зорчих хөдөлгөөнийг хэвийн үргэлжлүүлсүгэй.

2. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд 18 градусаас дээш агууламжтай согтууруулах ундааны зүйлсийг худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

3. Худалдааны төв, дэлгүүрүүдэд өргөн хэрэглээний болон хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн /Б.Одмаа/-д үүрэг болгосугай.

4. Үйл ажиллагаа явуулж буй төр, төсвийн болон аж ахуйн нэгж, байгууллага, үйлчилгээний газруудын ариутгал халдваргүйжүүлэлт, халдвар хамгааллын дэглэмийг сахиж буй байдалд хяналт тавьж, мэргэшил арга зүйн зөвлөгөө,

дэмжлэгээр ханган тайлан мэдээг нэгтгэн танилцуулж ажиллахыг сумын Эрүүл мэндийн төвийн дарга /У.Энхбямба/-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Ү.Янжиндулам/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ОТГОНЦОГТ